



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 25 өдөр

Дугаар А/22

Мөрөн сум

Эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.2, 46.3 аймгийн иргэдийн Төлөөлөгчдын Хурлын хуралдааны 2021 оны V дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдын Хурлын хуралдааны 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн V тогтоолоор батлагдсан 2022 оны төсвийн жилд зарцуулах аймаг, улсын аварга малчин, тариаланчдын шагналд зарцуулах 45,000,000 (Дөчин таван сая) төгрөгийг захиран зарцуулах эрхийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т шилжүүлсүгэй.

2. Шаардлагатай хөрөнгийг "Засаг дарга" данснаас гаргаж Хүнс, хөдөө аж ахуйн газрын нэмэлт төсвийн дансанд шилжүүлэхийг аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн Ерөнхий нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

3. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулж, баримтын бүрдлийг хангаж, тайлагнаж ажиллахыг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар (Я.Эрхэмбаяр)-т, гүйцэтгэлд нь хяналт тавьж арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Г.Базар)-т тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН